



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**



АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ

Салбар:

Хөдөө аж ахуй

Мэргэжлийн нэр:

Малын бага эмч

Улаанбаатар хот

2018 он

Ажил мэргэжлийн лавлах: Малын бага эмч

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулав.

ISBN:

Ажил мэргэжлийн лавлахын баталгаажилт

Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолт (YAMAT 08)-ын код:	3240-17
Хөтөлбөрийн индекс: Боловсролын Олон Улсын Стандарт Ангилал (ISCED-13):	Мал эмнэлгийн тусламж 0841-702
Баталсан байгууллага, огноо:	МБСУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоол
Баталгаажуулсан байгууллага, огноо:	Монголын Мал Эмнэлгийн Үндэсний Холбоо 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр
Хянан засварласан хувилбар, огноо	№ 01 2018 оны ... дугаар сарын ны өдөр
Хянан засварлах хугацаа	Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн тогтоож, өөрчлөлт орох эсвэл шаардлагатай тохиолдол бүрт
Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан аргачлал	ДАКУМ шинжилгээний аргачлал

Энэхүү ажил мэргэжлийн лавлахыг ХНХЯ-ны зөвшөөрөлгүйгээр олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.

АГУУЛГА

	Хуудасны дугаар
Өмнөх үг	3
Товчилсон үгийн тайлбар	4
1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ	5
2. Ажлын байрны товч тодорхойлолт	6
3. Ажлын байрны тухай мэдээлэл	6
3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл	
3.2 Ажлын байранд тавигдах шаардлага	
3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт	
3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал	
4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл	7
5 Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил	8
5.1 Мэдлэг	
5.2 Ур чадвар	
5.3 Хандлага, төлөвшил	
6. Үүрэг ба ажилбарын жагсаалт	8
7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо	11
8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл	12
9. Малын бага эмч мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл	13

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэл хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Малын бага эмч” мэргэжлийн ажил мэргэжлийн лавлахыг боловсруулав.

Мэргэжлийн боловсрол, сургалтад оролцогч талууд төрийн байгууллага, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод, ажил хайгч, оюутан, суралцагч зэрэг хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энэхүү ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан бөгөөд лавлахыг хэн хэрхэн ямар хэрэгцээнд зориулан ашиглаж болохыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- төрийн байгууллага хөдөлмөр эрхлэлт, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын талаар бодлого боловсруулах, хянах, хөдөлмөрийн харилцаатай холбогдох мэдээллийг авах, ажилтны ур чадварыг үнэлэхэд;
- ажил олгогчид нь ажлын байрны тодорхойлолт, аж ахуйн нэгж байгууллагын дотоод дүрэм, журам боловсруулахад;
- политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, түүнчлэн холбогдох их, дээд сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө боловсруулах, төгсөгчдийн ур чадварын үнэлгээ хийх, багш нарыг сургаж бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэхэд;
- ажил хайгч иргэд, суралцагчид нь ажлын байрны хэрэгцээ шаардлага, түүнд шаардагдах ур чадвар, мэдлэг, хандлага төлөвшил, хөдөлмөрийн нөхцлийн талаарх мэдээллийг олж авахад ажил мэргэжлийн лавлахыг ашиглаж болно.

Ажил мэргэжлийн лавлах нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно.

Мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, хийж гүйцэтгэх үүрэг, ажилбарыг салбарын зөвлөх, мэргэжилтэн, томоохон аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчид, мэргэжлийн холбоодын төлөөлөл, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн багш нарын мэдлэг, туршлагад тулгуурлан ажил мэргэжлийн дүн шинжилгээний ДАКУМ арга зүйгээр боловсруулсан.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын салбар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бодитоор нийцэж, төр, хувийн хэвшлийн түншлэл, шинэ техник технологи, шинэлэг арга зүйд тулгуурлан хөгжих болтугай.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
МБСБХЗГ	Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМЛ	Ажил мэргэжлийн лавлах
АМДШ	Ажил мэргэжлийн дүн шинжилгээ
АХБ	Азийн хөгжлийн банк
БАЗТ	Бүсийн арга зүйн төв
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөл
МБССЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын салбар зөвлөл
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ҮМХ	Үндэсний мэргэшлийн хүрээ
ХЭУЧД төсөл	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл

1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ

Энэхүү ажил мэргэжлийн лавлах нь ажлын байранд тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно. Уг лавлагаас дараах хэрэглэгчид шаардлагатай мэдээллийг олж авна. Үүнд:

Хэрэглэгч	Лавлагаас авах мэдээлэл
Төрийн байгууллага	<ul style="list-style-type: none">• Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үндэсний болон салбар, бүс, орон нутгийн түвшинд тодорхойлж боловсруулах;• Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт боловсруулах, ажлын байр, хөдөлмөрийн харилцааг зохицуулах асуудалтай холбогдох мэдээллийг авах;• Ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтны ур чадварыг үнэлэх;• Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх зорилгоор ашиглах.
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон Политехник коллеж	<ul style="list-style-type: none">• Ажил олгогчийн шаардлагад нийцсэн сургалтыг зохион байгуулах;• Тухайн мэргэжлийн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, багшийг сургаж бэлтгэх;• Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх;• Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, үйлдвэрлэлийн дадлагыг хамтран зохион байгуулах.
Ажил олгогч	<ul style="list-style-type: none">• Ажлын байрны тодорхойлолт, ажилтан сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулах;• Ажилтныг үнэлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшинг үнэлэх, цалинг тогтоох;• Ажлын ачаалал, нормыг тогтоох;• Ажилтныг давтан сургах, мэргэшүүлэхтэй холбогдсон сургалтын хэрэгцээг тодорхойлох, захиалгат сургалтыг төлөвлөх;• Сургалтын байгууллагатай хамтран ажиллах;• Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дээрх дадлагажуулах сургалтыг зохион байгуулах.
Иргэн ба ажил хайгч	<ul style="list-style-type: none">• Ажлын байрны нөхцөл, тавигдаж буй шаардлагын талаар мэдээлэл авах;• Ажлын байранд гүйцэтгэх үндсэн үүрэг, ажилбар, ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн талаар мэдээлэл авах;• Мэргэжлийнхээ хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийн талаар ойлголт авах;• Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухай мэдээлэл авах;• Ажлын байр, аж ахуйн нэгж байгууллагын талаар мэдээлэл авах.

2. Ажлын байрны товч тодорхойлолт

Малын бага эмч нь мал амьтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хийж байгаа оношлогоо, шинжилгээ, эмчилгээ, мал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, малын тэжээлд чанар, мал эмнэлэгийн ариун цэврийн магадлан шинжилгээ хийж баталгаажуулна.

3. Ажлын байрны тухай мэдээлэл

3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл

- Малын бага эмч нь мал эмнэлэг, малчны сууринд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан орчин нөхцөлд ажиллана.
- Малын бага эмч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна.
- Малын бага эмчийн ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тогтоосон норм, нормативын дагуу явуулна.
- Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага, зааварчилгаа болон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан нөхцөлд ажиллана.
- Малын бага эмч нь мал, амьтантай харьцах, малаас хүнд дамжин халдварладаг зооноз өвчин, туяа үүсгэгч төхөөрөмжтэй ажиллахад үүсч болзошгүй эрсдэлтэй мал эмнэлгийн үйлчилгээ зэрэг ажлын байртай холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамрагдана.
- Малын бага эмч нь хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллана.

3.2 Ажлын байранд тавигдах шаардлага

- Малын бага эмч техникийн боловсролтой, 18 нас хүрсэн иргэн байна.

3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт

- Мэргэжлийн дипломтой байна. Зарим тохиолдолд чадамжийн гэрчилгээ шаардагдаж болно.

3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал

- **Машин механизм:** Мал эмнэлэгийн авто машин гэх мэт.
- **Тоног төхөөрөмж:** Стерилизатор, угаалгын ванн, микроскоп, бодисын шил, дусаагуур, спиртэн дэн, лактоденсиметр болон PH метр, центрфуг, автоклав, сүүний шинжилгээний машин, овоскоп, хөргөгч, эм био бэлдмэлийн хөргүүр, ус нэрэгч, хүйтэн хэлхээний төхөөрөмж, ЭХО аппарат, рентген аппарат, шарлагын аппарат, аэрозолын аппарат, мотопомф, автомакс, дээж зөөх сав, GPS байршил тогтоогч гэх мэт.
- **Багаж хэрэгсэл:** Эмнэлэг, үйлчилгээний түргэн тусламжийн хайрцаг, мэс заслын, эх барихын иж бүрдэл, задлан шинжилгээний иж бүрдэл, чагнуур, халуун хэмжигч, тогшилтын алх /плессиметр/, шприц, зүү /уян, вакуум, тариур/, дуслын систем, бургуй, хаймсуур, эм олгогч, туузан метр, штангенциркуль, цусны зүү, хуруу шил гэх мэт.
- **Түүхий эд, материал:** Ороох, боох материал, нянгийн будаг, мах, сүү, өндөгний дээжүүд, мал эмнэлгийн эм, урвалж, тарилга гэх мэт.

- **ХАБЭА-н хэрэгсэл:** ХАБЭА-н шаардлагын дагуу анхны тусламжийн иж бүрдэл болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл

Ажлын байранд дараах хууль, дүрэм журам, стандартыг баримтална. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ.

Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- MNS 5080:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
- MNS 4994:2000 Доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
- MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
- MNS12.1.016:88 Хэт өндөр дуу, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
- MNS 5545 “Мал эмнэлгийн эмийн сангийн бүтэц үйл ажиллагаа”
- MNS 4244 “Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага”
- MNS 900 Ундны ус. “Эрүүл ахуйн хяналт, түүнд тавигдах шаардлага”
- MNS 5140 “Баримт бичиг.Баримт бичгийн нэр төрөл, тодорхойлт”
- MNS 5141 “Баримт бичиг. Баримт бичгийн бүрдлүүд, тэдгээрт тавигдах шаардлага”
- MNS 2010 Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагааны стандарт
- MNS 6036 Мал аж ахуй. Ичмэл үр хөврөл өсгөвөрлөх. Ерөнхий шаардлага
- MNS 6037 Мал аж ахуй. Үр хөврөл ичээлж хадгалах. Ерөнхий шаардлага
- MNS 6196 Үнээ хонь, ямааны үр хөврөл угаах, шилжүүлэн суулгах. Ерөнхий шаардлага
- MNS 5368-2:2011 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага
- MNS 5545:2005 Мал эмнэлгийн эмийн сангийн бүтэц, үйл ажиллагаа
- MNS 6035:2009 Мал эмнэлэг. Мах, махан бүтээгдэхүүн. Магадлан шинжилгээний цомог. Техникийн шаардлага
- MNS 6269:2011 Малын гаралтай бүтээгдэхүүн. Сүүний шинжилгээнд хэрэглэх урвалж Техникийн шаардлага
- MNS 4386:1996 Цусан халдвар өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4381:1996 Цусны ийлдсэнд уургийн задрагийг спектоколориметрийн аргаар тодорхойлох арга
- MNS 4389:1996 Стрептококийн халдвар үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS JIS K0883:2005 Мал эмнэлэг Хонь, ямааг сохор доголоос сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин. Техникийн шаардлага
- MNS 6015:2009 Мал эмнэлэг. Хонь, ямааг дотрын халдварт хордлого, брадзот, цусан суулгаас сэргийлэх идэвхгүйжүүлсэн хам вакцин. Техникийн шаардлага
- MNS 4939:2000 Ямааны цэцэг өвчнийг эсэргүүцэх хөнгөн цагааны усан исэлт формалинт вакцин Техникийн шаардлага
- MNS 6012:2009 Мал эмнэлэг. Үхрийг боом, дуут хавдраас сэргийлэх амьд вакцин. Техникийн шаардлага

- MNS 6085:2010 Мал эмнэлэг. Гахайн колибактериоз, салмонеллёзоос сэргийлэх хам вакцин
- MNS 4380:1996 Мал, амьтны эгэл биетэн, цусны паразитаар үүсдэг өвчнийг оношлох арга
- MNS 4395:1996 Иж сүрьеэгийн үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4394:1996 Адууны сахуу өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4391:1996 Зогсоо өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4306:1996 Малын туузан хорхойг устгах бэлдмэл-“ЗНК” Antliment “ZNK” praparar
- MNS 4387:1996 Ям өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4386:1996 Цусан халдвар өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 5199:2002 Адууны трипаносомоз өвчнийг оношлох шинжилгээний арга
- MNS 5201:2002 Мал, амьтны иж балнад. Ийлдэс оношлогооны арга
- MNS 5202:2002 Үхрийн кампилобактериоз. Ийлдэс оношлогооны арга-Наалдуулах урвал
- MNS 4374:1996 Некробактериозын үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4385:1996 Дуут хавдар өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4390:1996 Дотор халдварт хордлого, хурганы цусан суулга өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4392:1996 Ёлом өвчний үүсгэгчийг оношлох шинжилгээний арга
- MNS 4397:1996 Үхрийн лейкозыг оношлох ийлдэс судлалын оношлох шинжилгээний арга
- MNS 4398:1996 Мал амьтдын галзуу өвчнийг оношлох арга
- MNS 5979-5:2009 Эрүүл мэндийн технологи–Атгаал чөмөгний хугарлын оношлогоо, эмчилгээ
- MNS 5979-10:2009 Эрүүл мэндийн технологи–Дунд чөмөгний хугарлын оношлогоо, эмчилгээ
- MNS 5979-11:2009 Эрүүл мэндийн технологи – Шилбэний хугарлын оношлогоо, эмчилгээ
- MNS 5979-4:2009 Эрүүл мэндийн технологи - Мөрний сурмаг мултралын оношлогоо, эмчилгээ
- MNS 5911:2008 Малын эмнэлэг. Мал тэнхрүүлэх бэлдмэл-3. Техникийн шаардлага
- MNS 4373:1996 Өвчтэй ба үхсэн малын махыг ялган тогтоох аргууд
- MNS 5198:2002 Мал амьтны бруцеллёз. Ийлдэс судлалын шинжилгээний арга

5. Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил

5.1 Мэдлэг

- М 1. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох дүрэм журам
- М 2. Малын удмын сан эрүүл мэндийн тухай хууль тогтоомж
- М 3. Мал амьтан асрах үеийн ХАБЭА-г мөрдөж ажиллах
- М 4. Мал амьтны бие бүтцийн тогтоц, байршил судлах
- М 5. Эмгэг анатоми, физиологийг судлах
- М 6. Мал амьтны өвчин эмгэгийн оношийг зөв тогтоох
- М 7. Мал амьтанд эмнэл зүйн эмчилгээг хийх
- М 8. Мал амьтанд уламжлалт эмчилгээг хийх
- М 9. Бэлчээрийн мал аж ахуйн экологи, байгаль хамгаалал
- М 10. Төлийн өвчин эмгэгийг оношлож, эмчлэх
- М 11. Төл эх барих үйл ажиллагаанд тусламж үзүүлэх
- М 12. Мал амьтанд ажилбар, мэс засал хийх

- М 13. Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг аюулгүй ашиглах
- М 14. Ерөнхий дотрын халдваргүй өвчин
- М 15. Тусгай дотрын халдваргүй өвчин
- М 16. Халдварт өвчин оношлож, эмчлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
- М 17. Мал эмнэлгийн ариун цэвэр, магадлан шинжилгээг хийх
- М 18. Паразит өвчин оношилж, эмчлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах
- М 19. Эм тариаг зориулалтын дагуу бэлтгэж, найруулах, тарих, олгох аргачлалыг судлах
- М 20. Мал эмнэлэгийн менежмент
- М 21. Мал амьтнаас дээж авч тодорхой шинжилгээнүүдийг хийж оношийг тогтоох
- М 22. Компьютер, хэрэглээний програм хангамж

5.2 Ур чадвар

- УЧ 1. Эрсдэлийн үнэлгээ хийх, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, техникийн сааталгүй ажиллуулах болон энэ талаар зааварчилгаа өгөх
- УЧ 2. Мал амьтан сувилах, эмчлэх үеийн хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйг мөрдөж ажиллах
- УЧ 3. Байгалийн гамшгийн нөхцөлд, гоц халдварын голомтод ажиллах үеийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах
- УЧ 4. Мал амьтны бие бүтэц, үйл ажиллагааг судлах
- УЧ 5. Мал амьтны өвчин эмгэгийн зөв оношлох чадвартай байх
- УЧ 6. Мал амьтанд үзлэг хийж эмчилгээний оновчтой аргыг сонгож эмчлэх
- УЧ 7. Техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах, ашиглалтанд хяналт тавих
- УЧ 8. Мал амьтны мэс ажилбар хийхэд бэлтгэл ажлыг хийх, задлан хийх, боолт хийх
- УЧ 9. Мал амьтны төлийг эх барих, эмгэгийг оношилж, эмчилж, сувилах
- УЧ 10. Мал амьтны өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр малчдад сургалт зөвлөгөө өгөх
- УЧ 11. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн багаж хэрэгслийг ашиглан эмийн бодисыг сонгож ажлын уусмалыг бэлтгэж ашиглах
- УЧ 12. Гоц халдварт өвчний үеийн хорио цээрийг тогтоох ажлыг зохион байгуулах
- УЧ 13. Мал эмнэлгийн мэдээ тайланг боловсруулах, судалгааг гаргах, ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллах
- УЧ 14. Мал амьтантай зөв боловсон харьцах чадвартай байх
- УЧ 15. Малчдад зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулах
- УЧ 16. Ашигласан зүү тариурыг зориулалтын дагуу аюултай хог хаягдлын журмын дагуу устгалд оруулах
- УЧ 17. Гоц халдвараар өвчлөн үхсэн малын сэг зэмийг зориулалтын дагуу устгаж пайзжуулах
- УЧ 18. Тухайн бүтээгдэхүүнийг шинжлэн “Мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээ”-г тодорхойлж өгөх

5.3 Хандлага, төлөвшил

- Х 1. Мэргэжилдээ дуртай байх
- Х 2. Багаар ажиллах чадвартай, хамтач байх

- X 3. Бусдыг сонсдог, харилцааны соёлтой, ажлын байрны ёс зүйг сахидаг байх
- X 4. Ажилдаа бүтээлчээр ханддаг, санаачлагатай байх
- X 5. Ажлын хариуцлагатай байж цаг баримталдаг байх
- X 6. Хөдөлмөрийн сахилгатай байх
- X 7. Хувийн зохион байгуулалт сайтай байх

6. Үүрэг ба ажилбарын жагсаалт

Малын бага эмчийн хийж гүйцэтгэх ажил үүргийг ажилбараар ангилан тодорхойлов. Мэргэжлийн боловсрол, сургалтаар олгох боломжгүй дадлага ажлыг ажлын байрны бодит орчинд хийж гүйцэтгэх шаардлагатай ажилбаруудыг (*) тэмдэглэгээтэй үзүүлэв.


д/д	Үүрэг	Ажилбар
1	Ажлын байрыг бэлтгэх	<ul style="list-style-type: none"> - Өөрийгөө ажилд бэлтгэх * - Тээврийн хэрэгсэл аюулгүй байдлыг хангах* - Ажлын багаж тоног төхөөрөмж сонгох - Яаралтай тусламжийн хайрцаг бэлтгэх * - Ажлын байрны эрсдэл үнэлэх - Ажлын байрны аюулгүй байдлыг бүрдүүлэх - Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах - Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл өмсөх* - Багаж тоног төхөөрөмжийг ариутгах - Ажлын байрыг цэвэрлэх - Хог хаягдлыг горимын дагуу устгах
2	Мал амьтанд үзлэг хийх	<ul style="list-style-type: none"> - Малчнаас лавлагаа авах* - Мал амьтанд гадна үзлэг хийх - Мал амьтанд салст бүрхэвчийн үзлэг хийх - Мал амьтны биеийн халууныг үзэх - Мал амьтанд чагнах үзлэг хийх - Мал амьтанд барилах үзлэг хийх - Мал амьтанд тогших үзлэг хийх - Мал амьтны мэдэрхүйд үзлэг хийх
3	Мал амьтанд лабораторын шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Мал амьтны эдээс дээж авч, шинжилгээнд бэлтгэх* - Мал амьтнаас цус авах - Мал, амьтны ялгадаснаас дээж авч шинжлэх - Мал, амьтны арьс, салстанд шинжилгээ хийх - Малын мах, сүүнд шинжилгээ хийх - Өндөг, зөгийн баланд шинжилгээ хийх - Мал, амьтны гаралтай түүхий эдэд шинжилгээ хийх
4	Мал амьтны өвчин эмгэгийг оношлох	<ul style="list-style-type: none"> - Лабораторт оношлох ажилд бэлтгэх - Малын шинж тэмдгээр оношлох* - Мал амьтны паразитыг оношлох - Малын зарим халдварт өвчнийг хурдавчилсан оношлуураар оношлох - Мал амьтанд задлан шинжилгээ хийх*

5	Мал амьтанд жор барих	<ul style="list-style-type: none"> - Эм тариаг зориулалтын дагуу бэлтгэх - Эм тарианы нөөц бүрдүүлэх* - Эм тариаг зориулалтын дагуу хадгалах* - Эмийн борлуулалт хийх* - Орлого зарлагын баримт хөтлөх* - Эм, тарианы бүртгэл хөтлөх
6	Мал амьтанд эмчилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Малд эм олгох эмчилгээ хийх* - Мал амьтанд сувиллын эмчилгээ хийх* - Шинж тэмдгийн эмчилгээ хийх* - Малд физик эмчилгээ хийх* - Мал, амьтанд мэс ажилбар хийх* - Малд эх барих эмчилгээ хийх* - Мал, амьтанд хаймсуур \зонд\ тавих, эмчлэх* - Малыг уламжлалт аргаар эмчлэх* - Малд шингэн нөхөх эмчилгээ хийх*
7	Ариутгал халдваргүйжүүлэлт хийх	<ul style="list-style-type: none"> - Ариутгал, халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх - Малын байрыг халдваргүйжүүлэх* - Мал эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ариутгах - Малын тоноглолыг халдваргүйжүүлэх* - Тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх* - Малын уст цэгийг халдваргүйжүүлэх - Ариутгалын эмийн бодис, ажлын уусмалыг бэлтгэх* - Ажлын байранд механик цэвэрлэгээ хийх* - Малын бэлчээр, хөрсийг халдваргүйжүүлэх* - Тэжээлийн агуулахыг халдваргүйжүүлэх
8	Өвчнөөс урьдчилсан сэргийлэх	<ul style="list-style-type: none"> - Өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зөвлөн туслах* - Малд урьдчилан сэргийлэх боловсруулалт хийх* - Өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт хийх - Мал, амьтанд урьдчилан сэргийлэх тарилга хийх* - Мал, амьтанд урьдчилан сэргийлэх туулгалт хийх* - Мал, амьтанд урьдчилан сэргийлэх угаалга хийх*
9	Халдварын голомтод ажиллах	<ul style="list-style-type: none"> - Хувийн хамгаалах хэрэгсэл өмсөх, тайлах - Халдварт өвчний голомтод байршил тогтоох - Халдварт өвчний голомтод хил хязгаар тогтоох - Хяналтын цэг байгуулах* - Ариутгалын цэг байгуулах* - Устгалын цэг байгуулах* - Устгалын цэгийг халдваргүйжүүлэх - Хорио цээр, хязгаарлалт тогтоох* - Халдвараар өвчилсөн малыг устгах* - Өвчний голомтыг халдваргүйжүүлэх* - Хорио цээр, хязгаарлалтыг татан буулгах

10	Бичиг баримт боловсруулах	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны тодорхойлолт боловсруулах* - Хамтран ажиллах гэрээ байгуулах* - Мал эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулах* - Малын эм тарилгын захиалга хийх* - Мал эмнэлэгийн мэдээ гаргах - Санхүүгийн тайлан гаргах* - Өрхийн малын эрүүл мэндийн дэвтэр хөтлөх - Малын өвчлөлийн зураглал хийх* - Өвчний тандалтын судалгаа хийх - Мал амьтны гарал үүслийн гэрчилгээжүүлэлт хийх - Үхсэн, хорогдсон мал, амьтанд акт гаргах - Эмгэг задлан шинжилгээний тэмдэглэл хөтлөх - Өвчний мэдээ гаргах \сар, улирал, жил* - Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүртгэл хөтлөх - Мал, амьтанд “Өвчний түүх” бичих, хөтлөх - Ажлын тайлан гаргах
11	Малчинд мэдээлэл өгөх	<ul style="list-style-type: none"> - Малчинд өвчний тухай ойлголт өгөх* - Урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх* - Өвчний хор уршгийг тайлбарлах* - Эм, тарилгыг зөв ашиглах зөвлөгөө өгөх * - Хугацаат тарилга туулгалтын сургалт явуулах* - Суурь, хотын ариун цэврийн зөвлөмж өгөх* - Малтай зөв харьцах зөвлөмж өгөх* - Дур мэдэн эмчилгээ хийхгүй байх зөвлөмж өгөх* - Малын ашиг шимийг дээшлүүлэх сургалт явуулах* - Эрсдэлийн үнэлгээ хийх зөвлөмж өгөх*
12	Өөрийгөө хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Эмчилгээ хийх итгэмжлэл авах* - Гадаад хэлний мэдлэгээ сайжруулах* - Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх * - Бусдаас туршлага судлах* - Шинэ тоног төхөөрөмжийг судлах* - Шинэ эм тарилгыг судлах * - Боловсролын түвшин ахиулах* - Мэргэжлийн зэрэг ахиулах* - Илтгэх ур чадварыг сайжруулах* - Компьютерийн ур чадвар дээшлүүлэх* - Эмийн санчийн эрх авах*

7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо

Малын бага эмчийн бусад албан тушаалтантай ажиллах уялдаа холбоог дараах байдлаар дүрслэн харуулав.



Тухайн ажилтныг удирдах албан тушаал болон удирдуулан ажиллах ажилтныг босоо тэнхлэгээр харуулж байгаа бөгөөд энэ нь түүний өсч, дэвших боломжийг мөн илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, малын бага эмч нь малын их эмчийн удирдлага, хяналтан дор ажиллаж, санитарчийг удирдан, лаборанттай хамтран ажиллана.

8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл

Иргэн тухайн мэргэжлээр суралцах эсвэл ажил хайж байгаа тохиолдолд дараах мэдээлэлтэй танилцаж, сонголтоо хийх боломжтой.

Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох байгууллагуудын мэдээлэл	Ажил олгогч байгууллагуудын мэдээлэл
Тухайн мэргэжлээр бэлтгэдэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон политехник коллежийн талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу. http://www.asc.mn	Тухайн мэргэжлээр ажилтан хайж байгаа байгууллагуудын талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу. http://hudulmur-halamj.gov.mn/job/list

9. Малын бага эмч мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл

Ажил мэргэжлийн лавлахын ДАКУМ шинжилгээг боловсруулахад оролцсон багийн гишүүд:

- | | | |
|-----|---------------|---|
| 1. | И.Заяат | “РЭЗ” ХХК-ийн Малын эмч |
| 2. | Б.Цэрэнсамбуу | “Эко констракшн” ХХК-ийн Малын эмч |
| 3. | Т.Оюунцэцэг | “Чандмань Оточ” ХХК-ийн Малын эмч |
| 4. | С.Бат Өлзий | “Улам мандах” ХХК-ийн Малын эмч |
| 5. | Д.Мягмарсүрэн | “Нөхөрлөл ирээдүй” ХХК-ийн Малын бага эмч |
| 6. | Д.Мөнхбаяр | “Буян хөхий” ХХК-ийн Малын бага эмч |
| 7. | Т.Даваа | Мал эмнэлэг ариун цэврийн лаборатори,
Малын эмч |
| 8. | Ч.Батчулуун | “Лүн Мал” эмнэлэг, Малын эмч |
| 9. | Г.Гүндмаа | Өмнөговь аймаг Ханхонгор сумын Мал эмнэлэг,
Малын их эмч |
| 10. | С.Бямбаа | “Ачит жаргалан” ХХК-ийн Малын их эмч |
| 11. | М.Мөнхжаргал | “Овоот гол” ХХК-ийн Малын эмч |

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг баталгаажуулсан:

- | | | |
|-----|--------------|---|
| 1. | М.Болдбаяр | Төв аймгийн Лүн сум, Малын эмч |
| 2. | С.Даваахүү | Төв аймгийн Лүн сум, Малын эмч |
| 3. | Д.Батмөнх | ХААХҮ холбоо, Малын бага эмч |
| 4. | Б.Отгончимэг | Баянзүрх дүүргийн мал эмнэлэг, Малын бага эмч |
| 5. | Д.Энхээ | “Нөхөрлөл ирээдүй” ХХК-ийн Малын бага эмч |
| 6. | Д.Оюунбат | “Нөхөрлөл ирээдүй” ХХК-ийн Малын бага эмч |
| 7. | А.Амарбаян | “Буянхөхий” ХХК-ийн Малын бага эмч |
| 8. | Д.Батдорж | “Тэгшбуянт” ХХК-ийн Малын бага эмч |
| 9. | Т.Төмөрхуяг | Нийслэлийн мал эмнэлэгийн газар, Малын их эмч |
| 10. | Ц.Гантөмөр | Нийслэлийн мал эмнэлэгийн газар, Малын их эмч |
| 11. | Б.Пүрэвцэрэн | УМЭТ-ийн Ажилтан |
| 12. | У.Анхбаяр | Өмнөговь аймгийн Мал эмнэлэг, Малын бага эмч |
| 13. | Д.Буянбат | Өмнөговь аймгийн Мал эмнэлэг, Малын бага эмч |
| 14. | Б.Бямбацэрэн | Өмнөговь аймгийн Мал эмнэлэг, Малын бага эмч |
| 15. | Д.Ганзориг | УБ МЭҮА, Малын бага эмч |

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг хянасан хөдөө аж ахуйн салбарын экспертүүдийн төлөөлөл:

- | | | |
|----|--------------|---|
| 1. | Д.Батцэнгэл | “Сор” ХХК, Үйлдвэрлэл хариуцсан дарга |
| 2. | М.Мөнхжаргал | СБД-ийн Мал эмнэлэг, Малын их эмч |
| 3. | С.Гэрэлмаа | Малын эрдэм шинжилгээний хүрээлэн ЭША /гахайн сектор хариуцсан/ |

Ажил мэргэжлийн дүн шинжилгээний чиглүүлэгчид:

- | | | |
|----|--------------|--|
| 1. | Ч.Эрдэнэтуяа | ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш |
| 2. | Ё.Бадамхатан | ДАКУМ I зэргийн гэрчилгээт Сургагч багш,
Хангайн БАЗТ-ийн менежер |
| 3. | Б.Цолмон | ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, Төв аймгийн
Заамар сум дахь МСҮТ-ийн Багш |

Ажил мэргэжлийн лавлахын загварыг боловсруулж, хянасан зөвлөхүүд:

- | | | |
|----|-------------|---|
| 1. | Д.Адилбиш | ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Ахлах мэргэжилтэн |
| 2. | Ц.Ганчимэг | АХБ-ны ХЭУЧД төслийн ЧССҮ-ний мэргэжилтэн |
| 3. | Д.Энхбаатар | ЧССҮ-ний Үндэсний зөвлөх |
| 4. | Г.Батчимэг | ЧССҮ-ний Зөвлөх |

10. Малын бага эмчийн мэргэжлийн үүрэг, ажилбарын зураглал (Дакум шинжилгээ)

ҮҮРЭГ		АЖИЛБАР												
A	Ажлын байр бэлтгэх	A-1 Өөрийгөө ажилд бэлтгэх	A-2 Тээврийн хэрэгсэл аюулгүй байдлыг хангах	A-3 Ажлын багаж тоног төхөөрөмж сонгох	A-4 Яаралтай тусламжийн хайрцаг бэлтгэх	A-5 Ажлын байрны эрсдэл үнэлэх	A-6 Ажлын байрны аюулгүй байдлыг бүрдүүлэх	A-7 Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах	A-8 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл өмсөх	A-9 Багаж тоног төхөөрөмжийг ариутгах	A-10 Ажлын байрыг цэвэрлэх	A-11 Хог хаягдлыг горимын дагуу устгах		
		ABA	ABA	ABA	ACA	AAA	AAA	ACA	ACA	ABA	ACA	AAA		
B	Өвчнөөс урьдчилсан сэргийлэх	B-1 Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	B-2 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	B-3 Малд вакцин жуулалт хийх	B-4 Халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх	B-5 Паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх	B-6 Малын тарга хүчийг сайжруулах	B-7 Малд туулгалт хийх	B-8 Малд угаалга хийх	B-9 Малд боловсруулалт хийх	B-10 Малд таналт хийх			
		AAA	AAA	AAA	AAA	AAA	AAA	AAA	AAA	ABB	ABA			
C	Мал амьтанд (M/A) үзлэг хийх	C-1 M/A-ны биеийн бүтцэд үзлэг хийх	C-2 Малчнаас лавлагаа авах	C-3 M/A-д гадна үзлэг хийх	C-4 M/A-д салст бүрхэвчийн үзлэг хийх	C-5 M/A-ны биеийн халууныг үзэх	C-6 M/A-д чагнах үзлэг хийх	C-7 M/A-д гараар үзлэг хийх	C-8 M/A-ны мэдэрхүүд үзлэг хийх					
		AAA	AAA	AAA	AAA	ABA	ABA	AAA	ACA					
D	Мал амьтанд лабораторын шинжилгээ хийх	D-1 M/A-ны эдээс дээж авах	D-2 M/Aны цуснаас дээж авах	D-3 M/A-ны ялгадсанд шинжилгээ хийх	D-4 M/A-ны арьс салстанд шинжилгээ хийх	D-5 Малын сүүнд шинжилгээ хийх	D-6 Малын маханд шинжилгээ хийх	D-7 Малын өтөг бууцнаас дээж авах	D-8 Малын уснаас дээж авах	D-9 Малын бэлчээрээс дээж авах	D-10 Малын тэжээлээс дээж авах	D-11 Малын түүхий эдэд шинжилгээ хийх	D-12 Зөгийн баланд шинжилгээ хийх	E-13 Өндгөнд шинжилгээ хийх
		AAC	ABA	AAC	ABC	ABA	ABA	ACC	ACC	ACC	ACC	AAC	AAA	ABA
E	Мал амьтны өвчин эмгэгийг оношлох	E-1 Өвчнийг лабортороор оношлуулахад бэлтгэх	E-2 M/A-ны дотор паразитыг оношлох	E-3 Малын гадна паразитыг оношлох	E-4 Малын шинж тэм дэгээр оношлох	E-5 M/A-ныг оношлуураар оношлох	E-6 Мал амьтанд задлан хийх	E-7 Мэдэрхүүн эрхтэнээр оношлох						
		AAC	AAC	AAC	AAA	AAC	AAA	ABA						
F	Өвчний голомтод ажиллах	F-1 Голомтод байршил тогтоох	F-2 Голомтод хил тогтоох	F-3 Хяналтын цэг байгуулах	F-4 Ариутгалын цэг байгуулах	F-5 Устгалын цэг байгуулах	F-6 Халдвараар өвчилсөн малыг устгах	F-7 Устгалын цэгийг халдавруулах	F-8 Өвчний голомтыг халдаржуулах	F-9 Хорио цээрийг буулгах				
		ABC	ABC	ACC	ABC	ABC	AAC	ABC	ABC	ACC				
G	Мал амьтанд эмчилгээ хийх	G-1 Мал амьтанд сувиллын эмчилгээ хийх	G-2 Шинж тэмдгийн эмчилгээ хийх	G-3 Малд мэс ажилбарт бэлтгэх	G-4 Малд эх барих эмчилгээ хийх	G-5 Малыг зондоор эмчлэх	G-6 Малыг уламжлалт аргаар эмчлэх	G-7 Малыг утах аргаар эмчлэх	G-8 Малд шингэн нөхөх эмчилгээ хийх	G-9 Малд физик эмчилгээ хийх	G-10 Малд наркозын эмчилгээ хийх	G-11 Малд эм олгох эмчилгээ хийх	G-12 Малд тарилга (вакцин), угаалга, туулгалтын эмчилгээ хийх	G-13 Мал, амьтныг асрах
		ABC	AAA	AAC	AAC	AAC	ABB	ABB	AAA	AAC	AAC	AAA	ABC	ACA
H	Ариутгал халдваргүйжүүлэлт хийх	H-1 Ариутгалын тоног төхөөрөмжийг бэлтгэх	H-2 Ариутгалын эмийн бодисыг сонгох	H-3 Ариутгалын ажлын уусмалыг бэлтгэх	H-4 Ажлын байранд механик цэвэрлэгээ хийх	H-5 Малын байрыг ариутгах	H-6 Малын тоноглолыг халдвар гүйжүүлэх	H-7 Бэлчээрийг халдваргүйжүүлэх	H-8 Малын уст цэгийг халдваргүйжүүлэх	H-9 Тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх	H-10 Тэжээлийн агуулахыг халдваргүйжүүлэх			
		ABA	ABC	AAC	AAA	AAB	AAC	AAC	AAC	AAC	AAC			
I	Бичиг баримт боловсруулах	I-1 Ажлын байрны тодорхойлт боловсруулах	I-2 Хамтран ажиллах гэрээ байгуулах	I-3 Мал эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулах	I-4 Малын эм тарилгын захиалга хийх	I-5 Мал эмнэлэгийн мэдээ гаргах	I-6 Санхүүгийн тайлан гаргах	I-7 Анхан шатны бүртгэл хөтлөх	I-8 Өрхийн малын э/м дэвтэр хөтлөх	I-9 Малын өвчлөлийн зураглал хийх	I-10 Өвчний тандалтын судалгаа хийх	I-11 Иргэнд гарал үүслийн гэрчилгээжүүлэлт хийх	I-12 Үхсэн хорогдсон малд акт гаргах	I-13 Ажлын тайлан гаргах
		ABC	ACC	ACC	ACC	ACB	AAC	ABA	ACA	ABA	ABC	ACA	ACA	ABC
J	Малчинд мэдээлэл өгөх	J-1 Малчинд өвчний тухай ойлголт өгөх	J-2 Урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх	J-3 Өвчний хор уршгийг тайлбарлах	J-4 Эмийг зөв ашиглах зөвлөгөө өгөх	J-5 Хугацаат тарилга туулгалтын сургалт явуулах	J-6 Хотын ариун цэврийн зөвлөмж өгөх	J-7 Малтай зөв харьцах зөвлөмж өгөх	J-8 Дур мэдэн эмчилгээ хийхгүй байх зөвлөмж өгөх	J-9 Малын ашиг шимийг дээшлүүлэх сургалт явуулах	J-10 Эрсдлийн үнэлгээ хийх зөвлөмж өгөх			
		ACA	ACA	ACA	ACA	ACA	ACA	ACA	ACA	ACA	ACA			
K	Мал амьтанд эм барих	K-1 Эм тарианы нөөц бүрдүүлэх	K-2 Эм тариаг зориулалтын дагуу бэлтгэх	K-3 Эм тариаг зориулалтын дагуу хадгалах	K-4 Эмийн борлуулалт хийх	K-5 Орлого зарлагын баримт хөтлөх	K-6 Эм тарианы бүртгэл хөтлөх							
		AAA	AAA	AAA	AAA	ABA	ACC							
L	Өөрийгөө хөгжүүлэх	L-1 Эмчилгээ хийх итгэмжлэл авах	L-2 Гадаад хэлний мэдлэгээ сайжруулах	L-3 Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх	L-4 Бусдаас туршлага судлах	L-5 Шинэ тоног төхөөрөмжийг судлах	L-6 Шинэ эм тарилгыг судлах	L-7 Боловсролын түвшин ахиулах	L-8 Мэргэжлийн зэрэг ахиулах	L-9 Илтгэх ур чадварыг сайжруулах	L-10 Компьютерийн ур чадвар дээшлүүлэх	L-11 Эмийн сангийн эрх авах		
		AAC	AAB	ACB	ACB	ABB	ACB	AAC	AAC	ABB	ABB	AAA		

ТЭМДЭГЛЭЛ: Саарал өнгөтэй хэсэгт ажлын байран дээр ирэхээс өмнө сургалтын байгууллагаар олгох ажилбарыг заасан бөгөөд үүнийг сургалтын хөтөлбөрийн агуулгад заавал тусгана. Цагаан толгойн гурван үсгийн дарааллаар чухал, хүнд, давтамжийн үзүүлэлтүүдийн харьцангуй түвшинг илэрхийлдэг. Ингэхдээ эхний үсэг нь чухлын зэргийг (А-маш чухал, В-чухал, С-чухал биш), хоёр дахь үсэг нь ажилбарын хүндрэлийн түвшинг (А-маш хүнд, В-хүнд, С-хүнд биш), гурав дахь үсэг нь ажилбарыг гүйцэтгэх давтамжийг (А-байнга, В-заримдаа, С-ховор) илэрхийлнэ. Жишээлбэл: Ажилбарыг ABC гэж тэмдэглэсэн бол тухайн ажилбар нь маш чухал, хүнд, ховор гүйцэтгэдэг ажилбар гэсэн утгатай.

ТОВЧЛОЛ: ХАБЭА-Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, M/A – мал амьтан